



217 Page

# Иона

- Jonah-

**Тайлбарлагч** Эрт дээр үед Израильд Иона гэдэг хүн амьдардаг байжээ. Иона Бурханы үгийг дамжуулдаг хүн байлаа. Нэгэн өдөр Бурхан, Ионад ингэж хэлэв.

**Бурхан** "Ионаа, Чи Нинев хот уруу очоод тэнд амьдардаг хүмүүст хандан муу зүйл хийхээ боль гэж дамжуул"

**Тайлбарлагч** Нинев нь маш том хот байсан. Тэр хот нь баян бас хүчирхэг байлаа. Гэхдээ тэр хотынхон бие биенээ хайлаж мэдэхгүй. Үргэлж өөрийнхөө төлөө амьдардаг байлаа. Иона тэр хот уруу явах үнэхээр дургүй байв.

**Иона** "Тэр хотоор дүүрэн муу хүмүүс байгаа. Тэд муу зүйл хийснийхээ төлөө шийтгэл авах ёстой. Би тийшээ явахгүй байсан ч, Бурхан Өөрөө мэдээд шийтгэл өгөх байлгүй"



218 Page

**Тайлбарлагч** Иона Бурханы хэлсэн газар уруу явалгүй, Таршиш уруу явах усан онгоцонд суучихав. Гэтэл удалгүй далайн шуурга дэгдэхэд онгоцонд байсан хүмүүс сандарч эхлэв.

**Хүмүүс** Aaa! aaa! Амь авар, амь авар! !  
Бурханы уурыг хэн нэгэн хүргэжээ. Тэр хүн хэн бэ? Хэн гэдгийг нь мэдэцгээ!

Тэгье! Тэр нь дээр юм шиг байна.

**Тайлбарлагч** Хүмүүс, хэнээс болж гэнэт шуурга дэгдэх болсоныг мэдэхээр шавага хаяжээ. Гэтэл шавага Иона дээр тогтоход :


**Иона** Юу болох нь энэ вэ? Миний Бурхан шуургыг илгээжээ. Намайг далай уруу шидчих. Тэгвэл шуурга намдах болно.



219 Page

**Тайлбарлагч** Хүмүүс шуургыг зогсоохын тулд Ионаг далай уруу шидчихэв. Гайхалтай нь Ионаг далай уруу шидэх агшинд шуурга ч нам зогсжээ. Гэтэл далайд хаягдсан Ионаг халим залгичихаж гэнэ. Тэр халимыг Бурхан явуулсан ажээ. Ингээд Иона, халимын гэдсэнд гурав хоног байв .

**Иона** "Бурхан минь, намайг учлаарай. Миний амийг авраач!"



220 Page

**Тайлбарлагч** Бурхан Ионагийн залбиралыг сонсжээ. Халим түүнийг хуурай газар дээр нулимаад гаргачихжээ. Ингэж Иона амь аврагдаж, Бурханы тушаалын дагуу Нинев хот уруу явж Бурханы үгийг дамжуулж байлаа.

**Иона** "Хүмүүс ээ, дечин өдрийн дараа Бурхан энэ хотыг устгах гэж байна гэмшиж Бурханаас өршөөлийг гүйгаарай"



221 Page

**Тайлбарлагч** Иона өдөржин хотоор явж чанга дуугаар Бурханы үгийг дамжуулж байлаа. Нинев хотын хүмүүс, Ионагийн ярихыг сонсоод ихэд айцаав. Тэгээд тэд хоол ундаа ч идэж уулгүй Бурханд хандан чин сэтгэлээсээ залбирцгаав.

**Хүмүүс** “Бурхан минь, бидний гэм нүглийг уучилж өршөөгөөч! Энэ хотыг битгий устгаач дээ.”

**Тайлбарлагч** Бурхан тэдний чин сэтгэлийн залбиралыг сонсож, тэр хотыг уучилжээ. Ингээд Нинев хот болон тэнд амьдарч байсан хүмүүс бүгд амьд үлдجээ.